

Соёлын утгыг орчуулах арга зам

Г. Элдэв-Очир /МУИС, ГХСС/

Товч утга: *Хэл-сэтгэхүй-соёлын шүтэлцээний асуудал сүүлийн үед хэл шинжээчдийн анхаарлыг зүй ёсоор татах болсон хэл шинжлэлийн чухал судлагдахуун болоод байна. Хэл бол соёлыг илэрхийлэгч, дамжуулагч, хадгалагч төдийгүй үеэс үед өвлүүлдэг чухал хэрэгсэл юм. Иймд хэл соёл нь салиггүй холбоотой, харилцан нөхцөлдсөн шинжтэй байдаг учир соёл нь сэтгэхүүдээ тусч, сэтгэхүй нь хэлдээ нөлөөлж байдаг нь зайлиггүй билээ. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстний хэл-сэтгэхүй-соёл нь нягт нарийн шижмээр холбогдсоны дүнд соёлын утга бүхий үг хэллэг үүсч байдаг. Иймд орчуулга хийхэд хүндрэл учруулдаг зүйлүүдийн нэг нь цаад хэлний үндэстний соёлын утга бүхий үг хэллэгийг зөв оновчтой оноож буулгах явдал байдаг. Энэхүү үндэстний соёлын утгыг зөв оноон орчуулахын тулд цаад үндэстнийхээ түүх, соёл, сэтгэлгээг сайтар ойлгож, мэддэг байх шаардлага гарна.*

Түлхүүр үг: *Хэл-сэтгэхүй-соёлын шүтэлцээ, соёлын утга, орчуулгын арга*

Орчин цагийн хэл шинжлэлийн хөгжлийн чиг хандлага нь хүн төвтэй болж, өөрөөр хэлбэл, хүнийг гол судлагдахуунаа болгож, хүн-хэл хоёрын харилцан хамаарлыг чухалчилах болсон байна. Иймээс судлаачид соёлын үүднээс хэлийг судлахын зэрэгцээ хэлний үзэгдэл, материалд нь тулгуурлан тухайн үндэстний сэтгэлгээний онцлог, уламжлалт соёл зэргийг нь судалж байна.


Английн хүн судлаач Э. Тэйлор “Primitive culture”(1871) хэмээх бүтээлдээ хамгийн анх соёлын тодорхойлолтыг дэвшүүлснээс хойш олон судлаачид Э. Тэйлорын тодорхойлолтыг засч, нэмэн баяжуулсаар иржээ. Ерөнхийд нь авч үзвэл, соёл гэдэг нь байгаль, цаг агаар болон нийгмийн нөхцөл байдалтай уялдсан тухайн үндэстний амьдралын хэв маягаас үүдэлтэй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, тогтсон хэв шинжтэй, түүхэн хөгжлийн явцад бий болгож, засч баяжуулж ирсэн уламжлал, зан заншил, ертөнцийг үзэх үзэл, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлог, эд өлгийн зүйл гэх мэт эдийн болон оюуны бүтээлийн цогцийг хэлнэ.

Соёл нь хэлийг бүрдүүлэгч үндсэн нэгж болох үгийн санд юуны түрүүн туссан байдаг. Энэ талаар АНУ-ын нэрт хэл шинжээч, орчуулгын онолч Е.А. Найда “Үгийн сан нь тодорхой түвшинд хүний ертөнцийг танин мэдсэн ухамсар, ойлголтыг тусгаж байдаг. Иймд үгийн сан нь соёлыг тусгадаг хамгийн гол хэлний нэгж болдог” гэжээ. (Е.А. Найда, 2001:107) Жишээлбэл, Араб хэлэнд тэмээ болон тэмээний тоноглол зэрэгтэй холбоотой үг хэллэг, эскимосчуудын хэлэнд цастай холбоотой үг хэллэг, япон хэлэнд

загастай холбоотой үг хэллэг, монгол хэлэнд нүүдлийн мал аж ахуйтай холбоотой үг хэллэг үгийн сангийн багагүй хувийг эзлэдэг зэрэг нь дээрх үзэл онолыг баталж байгаа юм. Нэрт хэл шинжээч Ф.Р. Палмер (1976:181) “Хэл нь тэр үндэстэнийхээ түүх, соёл, шашин шүтлэг зэргийг бүгдийг нь илэрхийлдэг” гэж тэмдэглэсэн байдаг. Үүнээс үзэхэд, хэл соёл нь нягт холбоотой, түүнчилэн хэл бол гагцхүү соёлын бүрдүүлбэр биш, харин соёлыг илэрхийлэгч, дамжуулагч, хадгалагч юм гэдэг нь харагдаж байна. Тухайн үндэстний уламжлалт соёл, ёс заншил, амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлог зэргийг хэлээр нь дамжуулан ойлгож мэдэж болно.

Хэл, соёлын шүтэлцээнд сэтгэхүйн тухай асуудал чухал байр суурьтай байдаг. 19 зууны Германы нэрт хэл шинжээч В.Хумбольдт “Тухайн үндэстний хэл гэдэг бол тэдний оюун ухаан юм. Тэдний оюун ухаан бол тэдний хэл юм” (Ж. Баянсан, 2002:82) гэж тэмдэглэжээ. 20 зууны эхэн үед АНУ-ын нэрт хүн судлаач, хэл шинжээч Ф.Боас, Э.Сапир, Б.Уорф нар В.Хумбольдтын эл үзэл баримтлалыг эш үндэс болгон хэл, соёлын шүтэлцээг судалж, эл судлалд үнэтэй хувь нэмэрээ оруулжээ. Тэд өөрийн бичиг үсэг, хэлний материалгүй Америкийн уугуул иргэдийн хэлийг уламжлал, соёл, зан заншил, сэтгэлгээний онцлог зэрэгтэй нь уялдуулан судалсан байна. Үүний үр дүнд, Ф.Боас “Америкийн уугуул иргэдийн хэлний гарын авлага” хэмээх бүтээлээ туурвижээ. Тэрээр эл бүтээлдээ: “Тухайн үндэстний сэтгэлгээний онцлог нь хэлдээ туссан байдаг” гэж онцолжээ. (Гү Зязу, 2000:253) “Хэлний харьцангуйн онол”-ыг үндэслэгчдийн нэг Э.Сапир “Хэлний онол” хэмээх бүтээлдээ “Хэл бол сэтгэхүйн үйл ажиллагааны үр дүн юм. Иймээс тухайн үндэстний соёлыг тусгадаг. Хэл соёл нь ангид оршихгүй” (Ван Дөчүнь, 1998:266) гэжээ.

Хэдийгээр хэл, соёл нь нягт холбоотой боловч хоорондоо хүний сэтгэхүйгээр холбогддог. Өөрөөр хэлбэл, хэл, соёлын хооронд шууд холбоо байхгүй. Харин зөвхөн сэтгэхүйгээр дамжсан дам холбоо бий. Иймд хэл, сэтгэхүйн хооронд болон соёл, сэтгэхүйн хооронд шууд холбоо бий. Хүн юмс үзэгдлийг таниж, мэдэж, ойлгож авсанаар тэрхүү ойлголт, ухагдахуун нь хэлээр илэрч гардаг. Иймээс хэл – сэтгэхүй – соёл гурав салшгүй холбоотой болж байна. Үүнийг алдарт үгийн утгын гурвалжинг ашиглан үзүүлбэл:



Ийнхүү соёл нь сэтгэхүйдээ тусч, сэтгэхүй нь хэлдээ нөлөөлж байдаг нь зайлшгүй билээ. Өөрөөр хэлбэл, тухайн үндэстний хэл-сэтгэхүй-соёл нь нягт нарийн

шижмээр холбогдсоны дүнд соёлын утга бүхий үг хэллэг үүсч байдаг. Иймд орчуулга хийхэд хүндрэл учруулдаг зүйлүүдийн нэг нь цаад хэлний үндэсний соёлын утга бүхий үг хэллэгийг зөв оновчтой оноож буулгах явдал байдаг. Энэхүү үндэсний соёлын утгыг зөв оноон орчуулахын тулд цаад үндэстнийхээ түүх, соёл, сэтгэлгээг сайтар ойлгож, мэддэг байх шаардлага гарна.

Судалгаанаас үзэхэд, үндэсний соёлын утгыг дараах 5 аргаар орчуулж болохоор байна. Үүнд:

1. Шууд буюу үгчилэн орчуулах арга.

Энэ нь орчуулах эхийн агуулга, хэлбэрийг хадгалж тэр хэвээр нь шууд орчуулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, үндэсний соёлын утга бүхий үг хэллэгтэй дүйцэх үг нөгөө хэлэнд байвал тэр үг хэллэгээр шууд орчуулж болно гэсэн үг юм. Энэ нь хоёр үндэстэн урт удаан түүхийн явцад соёл, зан заншлын хувьд бие биедээ нөлөөлсөн, нэг нь нөгөөгөөсөө авсан гэх мэт олон хүчин зүйлийн үр нөлөө юм. Ийм аргаар орчуулахад уншигч, сонсогчид цаад хэлний утга, агуулга, сэтгэлгээг төвөггүй ойлгодог байх ёстой. Жишээлбэл, орос хэлний “красная армия” гэснийг монгол хэлнээ “улаан цэрэг”, хятад хэлнээ “红军” буюу “улаан цэрэг” хэмээн орчуулдаг нь угтаа орос, монгол, хятад оронд өрнөсөн түүхэн үйл явдалаас улбаатай тул тус тусийн хэлэнд мөн адил утга агуулга бүхий үг хэллэг болон хэвшсэн байна. Энд “улаан” өнгө илэрхийлсэн үг нь ижилхэн “хувьсгал” гэсэн үндэсний соёлын утга агуулж байгаа тул шууд орчуулж болох бөгөөд цаад агуулга нь гажихгүй юм.

2. Орлуулан орчуулах арга.

Нэг юм үзэгдэл үндэстнүүдийн соёл, сэтгэлгээний онцлогоос хамааран тухайн хэлнүүдэд өөр өөр соёлын утга агуулж болно. Иймд тэрхүү соёлын утга бүхий үгийг аль болох ойролцоо буюу тэнцүү түвшиний, өөрөөр хэлбэл, үгийн сангийн ижил аймгийн үгээр орлуулан орчуулбал илүү тустай юм. Энэхүү аргын ач холбогдол нь уншигч, сонсогчид өөрийн хэлний үндэсний соёлын утгаар баримжаа авч өөр үндэстний түүх, соёл, зан заншлыг ухаарч ойлгоход дөхөмтэй байдаг. Тухайлбал, нэрт эрдэмтэн Б.Ринчен гуай Гоголийн “Тарас Бульба” зохиолыг орчуулахдаа “упал как барашек, почуявший под сердцам смертельное железо” гэснийг “зүрхэндээ үхлийн зэв зоолгосон янзага шиг” хэмээн хургыг янзагаар орлуулан орчуулсан нь угтаа алдаа биш юм. Мөн англи хэлний “as strong as a horse” буюу “морь шиг тэнхээтэй” гэсэн хэлцийг хятад хэлнээ “力大如生” буюу “үхэр шиг тэнхээтэй” хэмээн орчуулдаг нь монгол хэлнээ ч адил бууж байна.

3. Нэмэлт зүүлт, тайлбар хийж орчуулах арга.

Уншигч, сонсогчидод ондоо үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээг гүн гүнзгий ойлгуулах үүднээс ойлгомжгүй үндэсний соёлын утга бүхий үг хэллэгийг шууд үгчилэн орчуулаад ард нь уг ойлголтыг тайлбарласан нэмэлт зүүлт, тайлбар оруулж болно. Ингэснээр хэлний цаана буй тухайн юм үзэгдэлийн талаарх соёлын мэдлэг, мэдээлэл нь

уншигчдад бүрэн ойлгогдох чухал ач холбогдолтой юм. Жишээлбэл, “Монгол гэр” – “Mongolian yurt” /...../

4. Утгачлан орчуулах арга.

Тухайн хэлний үндэсний соёлын утга бүхий үг хэллэгт нөгөө хэлэнд дүйцэх утга бүхий үг хэллэг байхгүй тохиолдолд орчуулах эхийн утга, агуулгыг голлож уншигч, сонсогчдод ойлгомжтой байлгах үүднээс утгачлан орчуулах шаардлага гардаг. Энэ бол үндэсний соёлын утгын дүйцэлгүй байх үзэгдэл билээ. Энэхүү үзэгдэл бол нэг үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээнд байдаг зүйл нөгөө үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээнд дүйцүүлэх зүйл байхгүй байж болох тохиолдол юм. Энэ бол маш түгээмэл байдаг. Ийм тохиолдолд үгчлэх буюу шууд орчуулбал уншигч, сонсогчдод ойлгомжгүй байхаас гадна төөрөгдөлд оруулдаг. Иймд заавал хэлбэрийг чухалчлалгүй агуулга, утгыг голлон буулгаваас зохилтой билээ. Тухайлбал, монгол хэлний “цагаан идээ” гэдэг үгний “цагаан” өнгө илэрхийлсэн үгэнд “сүү, сүүн бүтээгдэхүүн” гэсэн үндэсний соёлын утга бий. Энэ үгийг хятад хэлэнд шууд “白食” гэж орчуулбал ойлгомжгүй байх тул “奶品” буюу “сүү, сүүн бүтээгдэхүүн” гэж буулгавал сая ойлгомжтой болох юм. Мөн хятад хэлний “白事” гэдэг үг нь “буяны ажил буюу оршуулгын зан үйл” гэсэн үндэсний соёлын утгатай юм. Эл үгийг монгол хэлнээ шууд “цагаан ажил” гэвэл бидэнд ойлгомжгүй байна. Эс бөгөөс өөр утгаар ойлгогдох гэмтэй тул утгыг нь голлон “буяны ажил” гэж буулгавал сая ойлгомжтой болох буй заа.

5. Галиглан орчуулах арга

Тухайн үндэстний соёл, сэтгэлгээний өвөрмөц онцлог бүхий зарим юм үзэгдлийн нэрийг орчуулахад туйлын төвөгтэй байдаг. Ийм үгсийг галиглан орчуулах аргаар л орчуулж болдог. Жишээлбэл, хятад хэлний “功夫” буюу gongfu-г “кунфу”, “风水” буюу fengshui-г “фөншуи” хэмээн хэрэглэх зэрэг болно. Энд анхаарууштай нь харь үг хэллэгийг аль болох орчуулах шаардлагатай бөгөөд гагцхүү галиглаж орчуулахаас өөр аргагүй тохиолдолд л уг аргыг хэрэглэх нь зүйтэй юм. Учир нь тухайн орчуулж буй хэлд харь үг хэллэг олноор хэрэглэгдэх сөрөг талтай байдаг.

Ерөнхийд нь дүгнэж хэлбэл, хэл соёл нь салшгүй холбоотой бөгөөд хуудас цаасны хоёр тал мэт нэг нь нөгөөгүйгээр үл орших нэг юмны хоёр тал юм. Хэл, соёлын шүтэлцээ нь хэлбэр болон агуулгын харьцаа бөгөөд хэл нь хэлбэр, соёл нь агуулга болдог. Хэл нь үргэлж соёлоо тусгаж байдаг тул хэлийг ойлгоё гэвэл соёлыг нь мэдэх, соёлыг нь ойлгоё гэвэл хэлийг нь мэдэх шаардлагатай. Учир нь хэл соёл нь харилцан нөхцөлдсөн байдалтай бөгөөд соёл нь хэлээр илэрч, хэлд хадгалагддаг. Иймээс хэл бол үндэсний соёл, сэтгэлгээний толь мөн.

Ашигласан ном:

1. Ван Дөчүнь, Хэлийг олон талаас нь судлах нь, Бээжин: Цинхуа их сургуулийн хэвлэлийн газар, 2002
2. Гү Зязу, Хэл соёлын шүтэлцээ, Шанхай: Гадаад хэлний их сургуулийн хэвлэлийн газар, 2000
3. Nida .A.E, Language and culture contexts in translating, Shanghai, 2001
4. Palmer .F.R, Semantics, Cambridge, 1976
5. Равдан. Э, Орчин цагийн хэл шинжлэл, Улаанбаатар, 2005
6. Ци Юцүнь, Орчин үеийн хэл шинжлэлийн онцлог хийгээд хөгжлийн чиг хандлага, Шанхай: Гадаад хэлний их сургуулийн хэвлэлийн газар, 2001
7. Чэнь Сүзин, Соёл судлал, Бээжин: Үндэстний их сургууль, 2005
8. Элдэв-Очир.Г, Өнгө заасан үг хийгээд үндэстний соёлын утга зүй, Улаанбаатар, 2011